



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 10 өдөр


Дугаар 1/15

Мөрөн сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1, Захиргааны өрөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 352 дугаар тогтоол, 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 378 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- Хөвсгөл аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, аймгийн Засаг даргын тамгын газрын хүсэлтийг тус тус үндэслэн Мөрөн сумын 8 дугаар баг 6712017944 нэгж талбарын дугаартай төрийн захиргааны байгууллагын зориулалтаар эзэмшүүлсэн 3104m² газрыг "Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар" ТБАГ (РД:9070354)-т 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.
- Уг захирамжаар газар эзэмшиж байгаа хуулийн этгээд "Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар" ТБАГ (РД:9070354)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзүл) нарт тус тус зөвшөөрсүгэй.
- Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гармод гаргах эрхтэй болохыг дурдсугай.
- Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.



ДАРГА

П.ЛХАГВАЖАВ